



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/159

Чингис хот

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Гурван-Эрдэнэ” ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг /Хэрлэн/, Тэмүүжин гудамжид Ж-2а тоотод байршилтай үйлчилгээний зориулалттай 1006 м<sup>2</sup> газраас иргэн Энхболдын Болдтулгад 93 м<sup>2</sup> газрыг 38 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэдийн эзэмшил газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Н.Болдтулга болон “Гурван-Эрдэнэ” ХХК-ий захирал /Г.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 156 дугаар, 2003 оны 211 дүгээр захирамжийн 14, 15 дахь хэсгийг, 2012 оны 164 дүгээр, 1996 оны а/41 дүгээр захирамжуудыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



• 231010431

Аймгийн Засаг даргын 2021 оны  
03 дугаар сарын 25 өдрийн А/159  
дугаар захирамжийн хавсралт



**ХЭРЛЭН СУМАНД ГАЗАР ЭЗЭМШИЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ**

д/д	Иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	"Гурван-Эрдэнэ" ХХК	2644894	176м <sup>2</sup>	1-р баг Тэмүүжингийн гудамж Ж-2а-1	Үйлчилгээ	43
2	Энхболдын Болдтулга	СЭ90030714	93м <sup>2</sup>	1-р баг Тэмүүжингийн гудамж Ж-2а-2	Үйлчилгээ	43
3	"Гурван-Эрдэнэ" ХХК	4644894	736м <sup>2</sup>	1-р баг Тэмүүжингийн гудамж Ж-2а-3	Үйлчилгээ	43